



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2025 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 275

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрөл  
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 4 дүгээр тэмдэглэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 15,800,000.00 (арван таван сая найман зуун мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий 45-88 УНР улсын дугаар, КМНJT81BCBU327070 арлын дугаартай, Хьюндай тускан маркийн тээврийн хэрэгслийг хавсралтад заасны дагуу төрийн өмчийн данс бүртгэлээс хасч, засаж сэлбэн ашиглах зорилгоор Сэлэнгэ аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал Л.Баттөр, Сэлэнгэ аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга П.Эрдэнэсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор автомашиныг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийг орон нутгийн өмчит хуулийн этгээд (Сэлэнгэ аймгийн Боловсролын газар)-д эзэмшүүлэх, засан сэлбэн ашиглах, үнийг шинэчлэн тогтоож данс бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.4.Автотээврийн хэрэгслийг улсын бүртгэл, татвар төлөгчийг бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

133001336  
12-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2025 оны 05 дугаар сарын 30-ны/ний өдрийн  
... дугаар тогтоолын хавсралт

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,  
ДАНСНААС ХАСЧ, СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ  
АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашинны нэр, төрөл	Явсан км-ийн заалт	Үйлдвэрлэгдсэн, ашиглалтад орсон огноо	Арлын дугаар	Улсын дугаар	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	Хьюндай туксон (Hyundai Tucson) суудлын автомашин	170,892.00	2011	КМНJT81ВСВU327070	45-88 УНР	15,800,000.00
НИЙТ ДҮН						15,800,000.00
						(арван таван сая найман зуун мянга)